

МОНГОЛБАНКААР ДАМЖУУЛАН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АНХНЫ АРИЛЖААГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 217/A161 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжаалах журам”-ын хүрээнд 2012 оны 12 дугаар сарын 5-ны өдөр Монголбанкаар дамжуулан Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ)-ны анхны арилжааг зохион байгууллаа.

Уг арилжаагаар 1 сая төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 10.0 тэрбум ЗГҮЦ-ыг арилжихаар нийтэд мэдээлсэн бөгөөд банкуудаас нийт 29.0 тэрбум төгрөгийн ЗГҮЦ худалдан авах санал ирж, 10.0 тэрбум төгрөгийн Засгийн газрын хямдруулсан үнэт цаасыг 12.57 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр арилжааллаа.

Арилжааны дэлгэрэнгүй мэдээллийг дараах хүснэгтээс харна уу.

Засгийн газрын үнэт цаасны арилжааны мэдээлэл	
Арилжаалахаар зарласан нийт хэмжээ	10,000,000,000
Ирсэн саналын нийт хэмжээ	29,000,000,000
Биелсэн саналын нийт хэмжээ	10,000,000,000
Жигнэсэн дундаж хүү	12.57%
Биелсэн саналын хамгийн өндөр хүү	12.74%
Биелсэн саналын хамгийн бага хүү	12.20%